25

# КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА ПҮРЭВЖАВЫН БАЯНТҮМЭН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар

Нэгжийн нэр: Кадастрын хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 66.3 | 66.3 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. | 15 | 15 |
| 2. | Арга хэмжээ 2. | 15 | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 15 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 15 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 15 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15 |
| 4. | Манлайлах | 15 |
| 5. | Багаар ажиллах | 15 |
| 6. | Харилцаа | 15 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | 15 |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | 15 |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | 15 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 15 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт) 70 хүртэлх оноо* | 66.3 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ ) 15 хүртэлх оноо* | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ ) 15 хүртэлх оноо* | 15 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |

| | |
|---|---|
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | 96.3 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга (А.Энхманлай)

....... оны ...... дугаар сарын ..... -ны өдөр

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

Кадастрын хэлтсийн дарга .............................. (П.Баянтүмэн)

2024 оны 12 дугаар сарын 04-ны өдөр

## ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН КАДАСТРЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 05

### НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.10.**<br>**Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн системийг бий болгоно.** | | | | | | | |
| **1.20.1** | **Инженерийн дэд бүтэцтэй холбоотой мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх** | **Үйл ажиллагаа** | **Инженерийн дэд бүтцийн мэдээлэл** | **-** | **Төлөвлөлтийн инженерийн дэд бүтэц, бэлтгэл ажлын мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэсэн байна.** | | |
| 1.20.1.1 | Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр хэрэгжих инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээний зураг төсөл, төлөвлөлтийн давхаргын мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөлтийн 7 давхарга | - | Хот байгуулалтын кадастрын системд төлөвлөлтийн 7 давхаргын мэдээллийг улсын хэмжээнд бүртгэсэн байна. | “Нийслэл, 21 аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн цахим систем нэвтрүүлэх” 2023 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 2023/170 дугаартай зөвлөх үйлчилгээний ажлыг “Смарт дата” ХХК гүйцэтгэсэн бөгөөд эцсийн шатны тайланд захиалагчийн хяналт хийж хүлээн авсан. Ажил хүлээн авсан 2024/ГБ33/08 дугаартай акт болон КХ-01/2024 дугаартай дүгнэлтийг тус газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 1/694 дугаартай албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Тус хөгжүүлэлтээр инженерийн дэд бүтэц ус хангамж ариутгах татуурга, цахилгаан, дулаан хангамж, холбоо дохиолол, инженерийн бэлтгэл арга | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээний зураг төсөл төлөвлөлтийн мэдээллийг Хот байгуулалтын кадастрын цахим системд оруулах боломжтой болсон ба 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлэн төлөвлөлтийн нийт 7 давхарга мэдээллийг бүртгэн оруулж байна.<br>Тайлант хугацаанд цахим системээр улсын хэмжээнд архитектур төлөвлөлтийн даалгавар 1379, барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээ 334, инженерийн шугам сүлжээний ажил эхлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээ 17, барилгын ашиглалтад оруулах комиссын дүгнэлт 84 баталгаажсан байна. | |
| 1.20.1.2 | Барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын сүлжээний мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 45 давхаргын мэдээлэл | - | Барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын сүлжээний нийт 45 давхаргын мэдээлэл бүртгэгдсэн байна. | "Смарт дата" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн "Нийслэл, 21 аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн цахим систем нэвтрүүлэлт" зөвлөх үйлчилгээний ажилд захиалагчийн хяналт хийж, Барилга, хот байгуулалтын яаманд 2024/ГБЗЗ/08 дугаартай акт болон КХ-01/2024 дугаартай дүгнэлтийг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 1/694 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Тус хөгжүүлэлтээр барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын сүлжээний нийт 45 давхаргын мэдээлэл бүртгэх ажлыг энгийн ойлгомжтой болгож, 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>Тайлант хугацаанд 21 аймгийн хэмжээнд нийт 462 барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн байр зүйн зургийг мэдээллийн санд бүртгэн баталгаажуулсан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.20.1.3 | Нийслэл болон орон нутагт хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагааг хянах, удирдлагаар хангах | Үйл ажиллагаа | Зөвлөмжийн тоо | - | Нийслэл болон орон нутагт хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагааг хянах, удирдлагаар хангасан байна. | Хот байгуулалтын кадастрын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт хийгдэж дууссантай холбогдуулан 21 аймгийн нийт 150 албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 2024 оны 1, 2, 3 дугаар сард танхим болон цахим хэлбэрээр 8 удаа зохион байгуулж, системийн шинэчилсэн хувилбарыг 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 21 аймгийн хэмжээнд нэвтрүүлэн өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж удирдлагаар ханган ажиллаж байна. | 100 |
| 1.20.1.4 | Газар хөдлөлтийн чичирхийллийн идэвхжилтэй бүсийн мэдээллийг Хот байгуулалтын кадастрын цахим системд оруулах | Үйл ажиллагаа | Мэдээллийн тоо | - | Газар хөдлөлтийн чичирхийллийн идэвхжилтэй бүсийн мэдээллийг Хот байгуулалтын кадастрын цахим системд оруулсан байна. | Хот байгуулалтын кадастрын цахим системд нийт 13 аймгийн газар хөдлөлтийн бичил мужлалын бүсийн мэдээллийг 2024 оны 01 дүгээр сард бүртгэн оруулсан. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.21.<br>Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| **1.21.1** | **Улсын хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх** | **Үйл ажиллагаа** | **Хэрэгжилтийн хувь** | **2023 онд хяналт шалгалтад 97 объектыг хамруулж, нийт эрсдэлийн хувь 5% -аар буурсан, хууль сахин мөрдөлтийн хувь 5%-аар өссөн.** | **Газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон газрын төлөв байдал, чанарын хянан магадлагааны хэрэгжилтийг 80%-д хүргэсэн байна.** | | |
| 1.21.1.3 | Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Нийслэл дүүргийн Газар зохион байгуулалтын алба (12)-нд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо | - | Шалгалтаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна.<br>Хяналтын хуудсаар илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. | Тус ажлын хүрээнд Салбарын улсын ерөнхий байцаагчийн 35-00/04 дугаартай удирдамж батлуулж нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албанд төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай түүхчилсэн мэдээллийг Газрын кадастрын мэдээллийн системээс тухай бүр нэгтгэж ажилласан.<br>Нийслэл, дүүргийн хэмжээнд эрх бүхий этгээдийн шийдвэр гарч иргэн, хуулийн этгээдэд олгосон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 501,510 нэгж талбарын мэдээллийг нарийвчлан шалгаж, газар олголтын байдал, дуудлага худалдаа, төлбөрийн мэдээлэл, талбайн хэмжээ болон зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт шалгалтын ажлыг 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр газрын даргад танилцуулж, Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсэгт ажлын үр дүнг 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдөр танилцуулсан. | |
| 1.21.1.5 | Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын газар олголт, иргэн, хуулийн этгээдийн газар ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br>Шалгалтын дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/17 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хяналт, шалгалтын ажлыг нийт 6 багийн 24 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 17-ны хооронд хийж гүйцэтгэсэн.<br>Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн 41 сумдын хэмжээнд хийгдсэн хяналт шалгалтын ажлын үр дүнг Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсэгт 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдөр танилцуулсан бөгөөд тус хурлаар бусад 289 суманд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэхээр шийдвэрлэсний дагуу хяналтын ажлыг 289 сумын хэмжээнд нарийвчлан гүйцэтгэж байна.<br>Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай 35-00/07 дугаартай удирдамжийн хүрээнд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын хэмжээнд Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар гарган ажилласан. | 100 |
| 1.21.1.8 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна<br>Шалгалтын дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн нэгж талбарын судалгааг газрын даргын 2024 оны А/17 дугаар тушаалаар байгуулагдсан "Монгол улсын хэмжээнд иргэн хуулийн этгээдэд газар өмчлүүлсэн, эзэмшүүлсэн, ашиглуулсан асуудлыг шалгаж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах" үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд 21 аймгийн 41 суманд хийгдсэн хяналт шалгалтын ажлын хүрээнд зохион байгуулж эцэслэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулсан байна. | Тус ажлын үр дүнд мэдээллийн санд буруу болон алдаатай бүртгэсэн мэдээллийн жагсаалтыг аймаг, сум тус бүрээр боловсруулж, бэлтгэсэн бөгөөд аймгуудын ГХБХБГ-ын кадастрын асуудал хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулж, тус сургалтаар алдаатай мэдээллийг хэрхэн засварлах, сайжруулах талаар сургалт зохион байгуулж ажилласан.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн өгсөн үүрэг чиглэлийн хүрээнд 21 аймгийн 41 сум болон нийслэлийн 9 дүүргийг сонгон авч газар олголттой холбоотой хяналт шалгалтын ажлын тайланг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар хуралдаанд танилцуулсан бөгөөд хуралдааны тэмдэглэлээс өгсөн үүрэг даалгаврын хүрээнд аймаг, нийслэлийн Засаг даргад хэрэгжилтийг хангаж ажиллах талаар албан бичгийг хүргүүлж ажилласан.<br>Мөн хяналт, шалгалтын ажлын тайланг Засгийн газрын хэрэг эрхлэн газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар,т 2024 оны 1/2161, 1/2162, 1/2163, 1/2897 дугаар албан бичиг тус тус хүргүүлж ажилласан.<br>Монгол Улсын Шадар Сайдаар ахлуулсан ажлын хэсгийн хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу өмнө нь хяналт шалгалт хийсэн 41 сумдаас бусад 289 сумдад хяналт шалгалтыг үргэлжлүүлэн гүйцэтгэхээр газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/253 дугаар тушаалаар “Ажлын хэсэг” байгуулан ажлын удирдамжийн дагуу 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулж 21 аймгийн ГХБХБГ-ын удирдлага, холбогдох мэргэжилтэн, сумын газрын даамлуудад хяналт шалгалт хийх талаарх сургалт зохион байгуулсан. Мөн Төв, Завхан аймгуудын ГХБХБГ-ын хүсэлтээр холбогдох мэргэжилтэн сумдын даамлуудад 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдөр мөн цахим хуралдааныг зохион байгуулсан. 289 сумын хяналт шалгалтын ажлын тайлан бичих заавар, удирдамжуудын тайлан бичих зааврын асуудлаар тус бүр мэргэжил арга | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зүйгээр хангаж ажилласан. | |
| 1.21.1.9 | Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн нэгж талбарын цахим системд үүсгэсэн хувийн хэргийн (1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын) бүрдүүлэлтэд гүйцэтгэлийн хяналт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн "Газрын кадастрын цахим систем"-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт хийх, дүгнэлт гаргах, авах арга хэмжээний саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийн дагуу цахим системд үүсгэсэн хувийн хэргийн 1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын хувийн бүрдүүлэлтэд хяналт хийсэн. | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.<br>дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | Газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/272 дугаар тушаалаар Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт хийж, дүгнэлт гаргах, авах арга хэмжээний саналыг боловсруулах үүрэг бүхий ажлыг хэсгийг байгуулсан.<br>Ажлын хэсгээс "Газрын кадастрын цахим систем"-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд гүйцэтгэлийн хяналт хийж өмнөх онд гүйцэтгэсэн нийт 13,216 цахим хувийн хэргийн 15% буюу 1982 цахим хувийн хэрэгт гүйцэтгэлийн хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэсэн. Хяналт шалгалт хийгдсэн нийт 1982 материалаас зөв материал оруулсан 41.1 хувь, дутуу материал оруулсан 11,5 хувь, бөөнд нь сканердаж оруулсан 21,7 хувь, буруу материал оруулсан 31,6 хувь, хоосон цаас оруулсан 8.1 хувьтай тус тус бүрдүүлсэн байна. Цаашид зөрчил гаргахгүй байх, цахим архивын хөтлөлтийн талаар анхаарч ажиллах, илэрсэн зөрчлүүдийг арилгаагүй, давтан үйлдсэн тохиолдолд холбогдох албан хаагчдад арга хэмжээ авах талаар чиглэл хүргүүлсэн.<br>Мөн газрын даргын 2024 оны А/272 дугаар тушаалаар өмнө нь хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтын ажлын 15 хүртэлх хувь болон шийдвэрийн бүртгэлд тус тус хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсаны дагуу Улсын хэмжээнд цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт хийж зөрчил илэрсэн 1445 өргөдлийг сонгон цахим хувийн хэрийн баримт бичгийг өгөгдсөн чиглэлийн дагуу оруулсан хийсэн эсэхийг шалгах ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.22.**<br>**Хүн амын нутагшилт, суурьшлийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | | | |
| **1.22.1** | **Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг** | **Үйл ажиллагаа** | **5 хуулийн төсөл** | **Улсын хэмжээнд хэлэлцүүлэг** | **Хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байна.** | | |

| | боловсруулж Улсын Их Хуралд өргөн барих | | | зохион байгуулсан. | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.1.8 | Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлагдсан үзэл баримтлалын дагуу боловсруулж дуусган, олон нийтээр хэлэлцүүлж санал авах, Засгийн газарт өргөн барих | Үйл ажиллагаа | Хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл | Хуулийн төслийн үзэл баримтлал батлагдсан. | Батлагдсан үзэл баримтлал, хуулийн төсөлтэй холбоотой мэдээ, холбогдох судалгааг гаргах, олон нийтээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулж хуулийн төслийг эцэслэн Засгийн газарт өргөн барьсан байна. | Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Үзэл баримтлалыг 2023 онд Барилга, хот байгуулалтын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар баталсан.<br>ЗГ-аас шийдвэр гарч тус агентлаг нь Монгол Улсын Ерөнхий сайдын харьяанд шилжин ажиллах болсонтой холбогдуулан хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан.<br>Монгол Улсын Хаягжуулалтын тухай хууль, журам, заавар, стандартад дүн шинжилгээ хийж хууль эрх зүйн орчныг шинэчлэн найруулах үйл ажиллагаанд санал туршлага солилцох, системд суурилсан зам заагч системийн суурь өгөгдлийн сан бүрдүүлэх, олон улсын техникийн шаардлагыг үндэслэн хаягийн мэдээллийн системийг шинэчлэн байгуулах зорилгоор ГЗБГЗЗЕГ болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Дотоод хэрэг, аюулгүй байдлын яамтай хамтран ажиллах санамж бичгийг 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан. Санамж бичигт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхээр 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийн хугацаанд хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулж, сургалтаас гарсан үр дүнг Хаягжуулалтын хуулийн төсөлд тусгасан.<br>Хаягжуулалтын тухай хуулийн төслийг Монгол улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгах санал боловсруулан газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 1/2421 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>Мөн хаягжуулалтын тухай хуулийн үзэл баримтлалд оруулах нэмэлт саналыг газар, хэлтсийн дарга нараас авч нэгтгэн, Хуулийн хэлтэст хүргүүлсэн бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг батлуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 1/3225 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 90 |

| 1.22.2 | **Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох** | **Үйл ажиллагаа** | **Жил бүр 5-аас доошгүй эрх зүйн акт** | **Жил бүр 10 орчим эрх зүйн акт боловсруулж байна.** | **Нийт эрх зүйн актын 10 орчим хувийг шинэчилсэн байна.** | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.2.11 | "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам"-ын төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Журмын төсөл | Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 38 дугаар тушаалаар баталсан Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам, Газрын даргын 2020 оны А/181 дүгээр тушаалаар баталсан Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системийг ажиллуулах журмыг мөрдөж ажилласан. | **Эхний хагас жилд:** Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журмын төслийн холбогдох хэсгийг боловсруулж, ажлын хэсэгт хүргүүлсэн байна. | Газрын даргын 2024 оны А/194 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сан ажиллуулах журам"-ыг шинэчлэн хэрэглэгчийн эрхийн зохицуулалт, хэрэглэгч тус бүрийн эрхлэх үйл ажиллагааны зохицуулалт, ГКМС-ийн үндсэн үйл ажиллагааны зохицуулалтын талаарх саналыг боловсруулж, ажлын хэсгийн нарийн бичигт 2024 оны 02 дугаар сарын 24-ны өдөр хүргүүлсэн. Тус журмын төслийг Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж гарсан саналын дагуу сайжруулах арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж системийн хэрэглэгчийн эрхийн зохион байгуулалт болон эрхлэх үйл ажиллагааны хэсгийг дахин сайжруулж эцэслэсэн. Журмын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тус газрын даргын 2024 оны 1/3383 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. | 100 |



85

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.2.14 | “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын төслийг боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Журмын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл | ГЗБГЗЗГ-ын даргын 2021 оны А/187 тушаалаар баталсан журам | **Эхний хагас жилд:** Журмын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлэн батлуулсан байна. | Монгол Улсын Газрын тухай хуульд 2023 оны 11 дүгээр сарын 30, 12 дугаар сарын 07-ны өдөр тус тус орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд газрын даргын 2023 оны А/198 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын төслийг шинэчлэн боловсруулж, 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-аас 2024 оны 3/307 дугаар албан бичгээр, байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтээс тус тус 145 саналыг хүлээн авч нэгтгэсэн.<br>"Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын төсөлд ирүүлсэн саналыг тусган 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн ДДЗХ-аар танилцуулан хэлэлцүүлэн, хурлаас гаргасан шийдвэрийн дагуу гишүүдийн гаргасан саналыг журмын төсөлд тусган, эцэслэн боловсруулж, Засгийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр тус газрын 2024 оны 1/3383 дугаар албан бичгийг хүргүүлсэн. | 100 |
| 1.22.2.17 | “Газар эзэмших, ашиглах, эрхийн гэрчилгээ олгох, гэрчилгээг бусдад шилжүүлэх, гэрчилгээний хугацааг сунгуулахад төлөх хураамжийн хэмжээ”-г шинэчлэн боловсруулж Засгийн газраар батлуулах | Үйл ажиллагаа | 1 тогтоол | Засгийн газрын 2003 оны 205 дугаар тогтоолоор “Газар эзэмших, ашиглах, эрхийн гэрчилгээ олгох, гэрчилгээг бусдад шилжүүлэх, гэрчилгээний хугацааг сунгуулахад төлөх хураамжийн хэмжээ”-г баталсан. | **Эхний хагас жилд:** Газрын кадастрын мэдээллийн системээс үзүүлж буй цахим үйлчилгээний төлбөрийн хэм хэмжээг шинэчлэн тогтоож, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хураамжийг Засгийн газрын тогтоолоор батлуулсан байна. | Газрын даргын 2024 оны А/02 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд Газрын удирдлагын нэгдсэн цахим систем /egazar.gov.mn/ -ээс газрын харилцааны цахим киоск төхөөрөмжөөр дамжуулан иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээний нэгж зардлыг тооцоолсон. Тус судалгаанд үндэслэн 5 төрлийн лавлагаа, 6 төрлийн тодорхойлолт хэвлэх болон 20 төрлийн цахим хүсэлтийг илгээхэд төлөх төлбөр хураамжийн хэмжээг “Тэмдэгтийн хураамжийн тухай” хууль болон бусад журамд нийцүүлэн тодорхойлж ажлын хэсгийн нарийн бичигт 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөр хүргүүлсэн. Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дахин сайжруулах санал гарсны дагуу ГКМС болон egazar.gov.mn сайтаас үзүүлэх үйлчилгээний хэмжээг дахин шинэчилж, үнэ тооцсон аргачлалын дэлгэрэнгүй танилцуулгыг боловсруулж, ажлын хэсгийн нарийн бичигт хүргүүлсэн. Төслийг Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар | 100 |



86

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлэлцүүлж, "Үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоох тухай" 173 дугаар тогтоолыг батлуулсан. | |
| 1.22.2.33 | Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээллэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтын тоо<br><br>Хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн тоо | 5 удаагийн сургалт, мэдээллийн цагийг зохион байгуулсан. | Газрын харилцааны салбарт шинээр болон шинэчлэн батлагдсан эрх зүйн баримт бичгийг салбарын мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэх, танилцуулах сургалтыг зохион байгуулсан байна. | Засгийн газрын 2022 оны 432 дугаар тогтоолоор "Газрын нэгдмэл сангийн тайлан эрхлэх журам" шинэчлэн батлагдсан болон Аймаг, нийслэлийн Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг шинэ загварын дагуу гаргахтай холбогдуулан 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга болон холбогдох бусад мэргэжилтнүүдэд 2024 оны 01 дүгээр сарын 3-ны өдөр цахимаар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны удирдлага, мэргэжилтнүүдэд 01 дүгээр сарын 05-ны өдөр танхимаар тус тус Газрын нэгдмэл сангийн тайланг цахимаас гаргах, хүлээн авах, тайлагнахтай холбоотой сургалтыг зохион байгуулан ажилласан.<br>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу "Нэгж талбарын хувийн хэрэг хөтлөх журам"-ын нарийвчилсан зохицуулалтын талаар 21 аймгийн ГХБХБГ-ын Удирдлагын хэлтсийн дарга болон Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн, сумдын газрын даамлуудад 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр цахимаар зохион байгуулж ажилласан. Мөн газрын тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу эзэмших, ашиглахаар төлөвлөсөн газрын хэмжээ байршлыг ЗГ-ын хуралдаанаар батлах, газрын хэмжээ, байршил, зориулалт өөрчлөх зохицуулалт болон шинээр газар эзэмших хүсэлтийг цахимаар хүлээн авах үйл ажиллагаатай холбоотой танхимын сургалтыг нийслэлийн төвийн 6 дүүргийн ГЗБА-тай хамтран зохион байгуулж нийт 1256 орчим иргэд олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан. Мөн 21 аймгийн ГХБХБГ-ын кадастрын асуудал хариуцсан албан хаагчдад 2024 оны 05 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд танхимын сургалт зохион байгуулж Газрын тухай хуульд орсон өөрчлөлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэж ажилласан.<br>2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 18-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн ГХБХБГ- | 100 |



87

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ын мэргэжилтэн, сумдын даамлуудад, газрын удирдлагын нэгдсэн цахим систем (Egazar.gov.mn)-ийн нэмэлт хөгжүүлэлтийн ажлын талаар сургалт, мэдээлэл өгсөн. | |
| | | | | | | | |

## ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.5** | **Газрын нэгдмэл сангийн нэгдсэн системийн үйл ажиллагаар боловсронгуй болгох, хөгжүүлэлтийн ажлыг хийх, хэрэглээнд нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа, Урсгал төсөв** | **Газрын нэгдмэл сангийн нэгдсэн системийг хөгжүүлсэн нэмэлт өөрчлөлтүүд** | **Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.** | **Газрын нэгдмэл сангийн нэгдсэн системийн үйл ажиллагааны хөгжүүлэлтийн ажлууд хийгдэж боловсронгуй болсон байна.** | | |
| 2.1.5.1 | Газрын кадастрын мэдээллийн санд нэгж талбар, өргөдөл, гэрээ, хуулийн этгээд, шийдвэр зэрэг өдөр тутамд хийгдэж буй засварыг 21 аймаг, нийслэл, дүүргийн асуудал хариуцсан албан хаагчид гүйцэтгэх, хэрэглэгчийг тухай бүр хянах боломжийг бүрдүүлсэн “Засвар, хяналтын модуль”-ийг хөгжүүлж хэрэглээнд бүрэн нэвтрүүлэх | Урсгал зардал | Систем хөгжүүлсэн байдал | Газрын кадастрын мэдээллийн систем хэрэглээнд нэвтэрсэн. | Урсгал зардлаар гүйцэтгэх ажлын удирдамжид тусган батлуулах, хууль, журмын дагуу гүйцэтгэгч шалгаруулж гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэгч байгууллагатай хамтран ажилласан байна. Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг бүрэн хүлээн авсан байна. | Тус ажлын хүрээнд 2024 оны “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагааг хангах” АД/2024-31 дугаартай ажлын даалгаварт тус хэлтсээс Газрын кадастрын цахим систем хөгжүүлэлтийн 18 төрөл, Газрын удирдлагын нэгдсэн цахим систем (Egazar.gov.mn)-ийн хөгжүүлэлтийн 7 төрөл, Egazar гар утасны аппликейшний хөгжүүлэлтийн 9 төрөл нийт 34 төрлийн ажлыг тусгаж батлуулсан. Тус ажлын гүйцэтгэгчээр “Софт мастер” ХХК шалгарч, 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 2024/198 дугаартай гэрээг байгуулсан. Гүйцэтгэгчтэй нийт 16 удаагийн хурлыг зохион байгуулж, 21 аймаг, нийслэл, дүүргийн албан хаагчдын Газрын кадастрын мэдээллийн системд бүрдүүлсэн мэдээллийг хянах, нэгж талбар, өргөдөл, гэрээ, хуулийн этгээд, эрх бүхий этгээдийн шийдвэр зэргийг засварлах “Засвар хяналтын модуль”-ийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлэн болгосон. Засвар хяналтын модулийг үйл ажиллагаандаа хэрхэн ашиглах талаар сургалт мэдээллийг холбогдох албан хаагчдад өгч, 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс хэрэглээнд нэвтрүүлнэ. | |
| 2.1.5.2 | Газрын кадастрын мэдээллийн санд эрх бүхий этгээдийн бүх төрлийн шийдвэрийн төслийг загварчлан нууцлал бүхий QR кодтой болгож захирамжийн хавсралтыг *.pdf болон бусад байдлаар татагдах боломжтой байдлаар хөгжүүлж, захирамжийн модулийг бүрэн автоматжуулах | Урсгал зардал | Систем хөгжүүлсэн байдал | Газрын кадастрын мэдээллийн систем хэрэглээнд нэвтэрсэн. | Урсгал зардлаар гүйцэтгэх ажлын удирдамжийн саналд тусгаж батлуулах, хууль, журмын дагуу гүйцэтгэгч шалгаруулж гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэгч байгууллагатай хамтран ажиллах.<br>Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг бүрэн хүлээн авсан *байна*. | Тус ажлын хүрээнд 2024 оны "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагааг хангах" АД/2024-31 дугаартай ажлын даалгаварт тус хэлтсээс Газрын кадастрын цахим систем хөгжүүлэлтийн 18 төрөл, Газрын удирдлагын нэгдсэн цахим систем (Egazar.gov.mn)-ийн хөгжүүлэлтийн 7 төрөл, Egazar гар утасны аппликейшний хөгжүүлэлтийн 9 төрөл нийт 34 төрлийн ажлыг тусгаж батлуулсан. Тус ажлын гүйцэтгэгчээр "Софт мастер" ХХК шалгарч, 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 2024/198 дугаартай гэрээг байгуулсан. Гүйцэтгэгчтэй нийт 16 удаагийн хурлыг зохион байгуулж, Газрын кадастрын мэдээллийн системд эрх бүхий этгээдийн шийдвэрийг бүртгэх үед pdf* өргөтгөлөөр заавал хавсаргаж, илгээгдэх хавсралт материалуудыг QR кодоор баталгаажуулан, тухайн хавсаргасан материалыг устгах болон өөрчлөх боломжгүй, зөвхөн энэхүү хавсралтыг бүртгэсэн этгээд устгах боломжтой байдлаар хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн. Хөгжүүлэлтийн ажлын явцад тогтмол хяналт тавьж ажилласан бөгөөд 2024 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс Газрын кадастрын мэдээллийн системд хөрвүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. | 100 |
| 2.1.5.3 | Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн тусгай хамгаалалтай газар нутгийн давхаргын мэдээллийг нарийвчлан шалгаж, алдаа дутагдлыг засварлах, бүртгэл, мэдээллийг сайжруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Бүртгэл, мэдээлэл бүрдүүлсэн байдал | Тусгай хамгаалалттай газар нутгийн давхаргад 565 нэгж талбарын мэдээлэл бүртгэлтэй. | Тусгай хамгаалалттай газрын давхаргад бүртгэлтэй нэгж талбаруудыг батлагдсан тогтоолын дагуу тулгах, шалгах ажлыг гүйцэтгэсэн байна.<br>Засгийн газар, УИХ-ын тогтоолоор авсан тусгай хамгаалалттай | - Тус ажлын хүрээнд УИХ болон ЗГ-ын тогтоолын хавсралтаар батлагдсан эргэлтийн цэгээс зөрүүтэй бүртгэгдсэн мэдээллийг ГКМС-д засварлах эрхийг тусгай хэрэгцээний асуудал хариуцсан мэргэжилтэн гүйцэтгэхээр системийн тохиргоог гүйцэтгэж, эргэлтийн цэг зөрүүтэй бүртгэгдсэн 52, талбайн хэмжээ зөрүүтэй бүртгэгдсэн 125 мэдээллийг засварласан.<br>- Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанаас ирүүлсэн хүсэлтийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газруудын мэдээллийг Газрын кадастрын мэдээллийн санд нарийвчлан шалгаж засварлан үнэн зөв мэдээллээр иргэд, олон нийтийг хангах боломж бүрдсэн байна. (Дорнод-12/04, Говь-Алтай-10/10, Дархан-10/10, Дундговь-10/10) | дагуу Газрын кадастрын мэдээллийн системд Нийслэлийн засаг даргын захирамжаар буруу холбогдсон 108 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын шийдвэртэй холбож, засварласан.<br>- Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэлтэй "Тусгай хамгаалалттай газар нутгийн давхарга"-ын 102 мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 04/4488 дугаартай албан бичгээр ирүүлсэн 103 мэдээлэлтэй тулган шалгаж, зөрүүтэй 3 мэдээллийг ГКМС-д засварлан, үнэн зөв бүрдүүлж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.5.4 | Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн орон нутгийн тусгай хамгаалалттай газрын давхаргын мэдээллийг нарийвчлан шалгаж, алдаа дутагдлыг засварлах, бүртгэл, мэдээллийг сайжруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Бүртгэл, мэдээлэл бүрдүүлсэн байдал | Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн давхаргад 1657 нэгж талбарын мэдээлэл бүртгэлтэй. | Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын давхаргад бүртгэлтэй нэгж талбаруудыг нарийвчлан шалгах ажлын аргачилсан заавар боловсруулж, 21 аймгийн ГХБХБГ-т хүргүүлэх, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах, Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээлэл нарийвчлагдан үнэн зөв мэдээллээр иргэд, олон нийтийг хангах боломж бүрдсэн байна. | Тус хэлтсээс 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрүүдэд 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Кадастрын асуудал хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалтын зохион байгуулж, "Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн орон нутгийн тусгай хэрэгцээний газрын давхаргад хяналт шалгалт хийж, зөрүүтэй бүртгэгдсэн мэдээллийг эрх бүхий этгээдийн шийдвэрт үндэслэн засварлах, шинээр орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрыг бүртгэж баталгаажуулах" ажлыг гүйцэтгэх талаар чиглэл өгсөн.<br>Мөн орон нутгийн тусгай хамгаалалттай газрын давхаргад бүртгэлтэй нэгж талбаруудыг нарийвчлан шалгах ажлын аргачилсан зааврын видеог хийж, 21 аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдэд хүргүүлсэн.<br>Газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 1/2375 дугаартай албан бичгээр 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газарт "Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн орон нутгийн тусгай хэрэгцээний газрын давхаргад хяналт шалгалт хийж, буруу, зөрүүтэй бүртгэгдсэн мэдээллийг эрх бүхий этгээдийн шийдвэрт үндэслэн засварлах ажлыг гүйцэтгэх талаар чиглэлийг хүргүүлж, 5 аймгийн 630 мэдээллийг газрын кадастрын мэдээллийн системд засварлуулж, үнэн зөв мэдээллээр иргэд, олон нийтийг хангах боломжийг бүрдүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.5.5 | Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх, байнга шинэчлэгдэж байх боломжтойгоор системийн хөгжүүлэлтийг хийх | Үйл ажиллагаа | Дундын мэдээллийн сан-1 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэдэг болсон байна. | МУ-ын Ерөнхий сайдын 2023 оны 107 дугаар тушаалаар байгуулагдсан "ЗГ-ын 2020 оны 110 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах" үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газартай 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Уулзалтын хүрээнд Хот байгуулалт хөгжлийн газрын Ebarilga.ub.gov.mn цахим системд бүртгэгдсэн 11152 инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний хамгаалалтын зурвасын мэдээллийг тус газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 01-05/732 дугаартай албан бичгээр хүлээн авсан.<br>Мөн "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг байгууллагуудын мэдээллийн сантай холбож, дундын мэдээллийн санг байгуулах" АД/2024-52 дугаартай ажлын даалгаварт газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд хөгжүүлэлт хийх 2 төрлийн ажлыг тусгаж батлуулсан. Тус ажлын гүйцэтгэгчээр "Софт мастер" ХХК шалгарч, 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 2024/325 дугаартай гэрээг байгуулж, систем хөгжүүлэлтийн ажлын эцсийн шатны тайланг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хүлээн авахаар ажиллаж байна. | 100 |
| 2.1.5.6 | Газрын кадастрын мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах, мэдээллийн санд оруулж буй өөрчлөлтөд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах | Үйл ажиллагаа | 7 системийн хэвийн үйл ажиллагаа *(Газрын Кадастр, үнэлгээ, төлбөр, татвар, бирж, хаяг, Газрын нэгдмэл сангийн систем)* | Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим мэдээллийн сан | Мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. | Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтнүүд, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Чөлөөт бүс, Тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны албан хаагчид болон сумын газрын даамлуудад өдөр тутам мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, Газрын кадастрын мэдээллийн системд үүссэн өдөрт дунджаар 40-50, сард 800, жилийн эцсийн байдлаар 5750 орчим мэргэжилтэнтэй холбогдон системд оруулсан бүртгэлийн алдааг засварлаж, Газрын кадастрын мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан. | 100 |



92

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн Газрын кадастрын мэдээллийн системд иргэний гэр бүлийн хэрэгцээнд үнэ төлбөргүй газар эзэмших үйл ажиллагааг цахим системээр зохион байгуулах, эрх бүхий этгээдийн шийдвэр гаргуулах, Улсын бүртгэлийн Э, А дугаар авах, засвар хяналтын модулийг нэвтрүүлэх, ГКМС-д байршил зөрүүтэй бүртгэгдсэн нэгж талбаруудыг засварлах, нэгж талбарыг нөхөн бүртгэх зэрэг шинэчлэлт, хөгжүүлэлтийн талаар чиглэлүүдийг албан бичгээр хүргүүлж, 25 удаагийн сургалт мэдээллийг танхимаар болон цахимаар зохион байгуулж ажилласан.<br>Мөн Монголын Кадастрын холбоотой байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Газрын кадастрын мэдээллийн системийн сертификат олгох 6 удаагийн шалгалтыг зохион байгуулж, 19 суралцагчид сертификатыг олгосон. | |
| 2.1.5.7 | Улсын бүртгэлийн ерөнхий газартай дундын мэдээллийн санг байгуулж, Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх | Үйл ажиллагаа | 3 системийг холбосон дундын мэдээллийн сан-1 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн. | Үндэсний ДАТА төвийн ХУР системд дундын мэдээллийн санг байгуулах системийн хөгжүүлэлтийн ажлыг эцэслэн дуусгаж хаягийн мэдээллийн системд бүртгэгдсэн өгөгдөл мэдээллийг сервис байдлаар байршуулсан байна. | - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нарын 2023 оны А/82, А/985 дугаар хамтарсан тушаалаар байгуулсан “Хаягийн болон газар, үл хөдлөх хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах” ажлын хэсгийн хүрээнд нийт 4 удаагийн уулзалт зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн санг байгуулах ажлыг эрчимжүүлж газар өмчлөгчийн анхны болон эцсийн өмчлөгчийн мэдээллийг ГКМС-д холбох ажлыг “Софт мастер” ХХК-аар гүйцэтгүүлж, УБЕГ-тай дундын мэдээллийн сангийн анхны хувилбарыг туршиж байгууллага хоорондын мэдээлэл дамжих виртуал сервисийг үүсгэсэн. Мөн газар өмчлөгчийн түүхчилсэн мэдээллийг сервис байдлаар холбох ажлыг гүйцэтгэж, ГКМС-ийн өмчлөлийн бүртгэлд “ТҮҮХ” гэсэн талбарыг шинээр хөгжүүлсэн. Энэ хэсэгт улсын хэмжээний 711 мянган газар өмчлөгчийн мэдээллийн анхны өмчлөгч болон эцсийн өмчлөгчийн мэдээллийг холбоход бэлэн болсон бөгөөд эхний удаад Нийслэлийн хэмжээний 210 мянган газар өмчлөлийн мэдээллийг холбож хэрэглээнд нэвтрүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Дээрх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нарын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/275, А/152 дугаар хамтарсан тушаалаар шинэчилж байгуулсан. Ажлын хэсгээс нийт 3 удаагийн уулзалтыг зохион байгуулж, дундын мэдээллийн санг улсын хэмжээнд нэвтрүүлэх, холбогдох арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулахаар ажиллаж байна. | |
| 2.1.5.8 | Хаягийн мэдээллийн системийн үндсэн үйл ажиллагаанд бүрэн шинэчлэлт хийх ажлыг зохион байгуулж, орц гарц болон нэгж талбарт хаяг олгох боломжийг бүрдүүлсэн нэмэлт хөгжүүлэлт гүйцэтгэж хэрэглээнд нэвтрүүлэх | Урсгал зардал | Систем хөгжүүлсэн байдал | Хаягийн мэдээллийн систем хэрэглээнд нэвтэрсэн. | Хаягийн мэдээллийн системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.<br>Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг бүрэн хүлээн авсан байна. | Тус ажлын хүрээнд "Хаягийн нэгдсэн системийн хөгжүүлэлт (хаяг олгох үйл ажиллагааг автоматжуулах, цахимжуулах ажил)"-ын АД/2024-04 дугаартай ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан. Гүйцэтгэгчээр "Софт мастер" ХХК шалгарч, 2024 оны 03 сарын 22-ны өдөр ажил гүйцэтгэх 2024/72 дугаартай гэрээг байгуулсан. Гэрээнд туссан ажил гүйцэтгэх хуваарийн дагуу явцын тайланг Даргын дэргэдэх зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 12 дугаар, эцсийн тайланг 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 21 дүгээр хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн дараах шийдвэр гарсан. Үүнд:<br>- Гэрээт ажлын эцсийн шатны тайланг зохих журмын дагуу хүлээн авах, санхүүжилтийг гэрээний дагуу олгох | 100 |



94

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Хаягийн нэгдсэн системийн хөгжүүлэлттэй холбоотой Хаягжуулалтын тухай хууль, журам, стандартыг шинэчлэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэх<br>- Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд Хаягийн мэдээллийн системийг нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах<br>- 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд чиглэл хүргүүлэн, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг холбогдох газар, нэгжүүдэд үүрэг болгосон.<br>Гэрээт ажлын эцсийн шатны тайланг шалгаж, хүлээн авсан тайланг холбогдох материалын хамт 2024 оны 10 дугаарын 24-ний өдөр Салбарын архивын хэлтэст хүлээлгэн өгсөн. | |
| 2.1.5.9 | Хаягийн мэдээллийн системээс хаяг олгох үйлдлийг бүрэн автоматжуулах, хаягийн мэдээллийн сангийн хэрэглэгчид тайлан гаргах боломжийг бүрдүүлэх хөгжүүлэлтийн гүйцэтгэх | Урсгал зардал | Систем хөгжүүлсэн байдал | Хаягийн мэдээллийн систем хэрэглээнд нэвтэрсэн. | Хаягийн мэдээллийн системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан гүйцэтгэгч шалгаруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.<br>Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг бүрэн хүлээн авсан байна. | “Хаягийн нэгдсэн системийн хөгжүүлэлт (хаяг олгох үйл ажиллагааг автоматжуулах, цахимжуулах ажил)” 2024/72 дугаартай гэрээт ажлын гүйцэтгэх хуваарийн дагуу “Хаягийн мэдээллийн сангийн хэрэглэгчид тайлан гаргах боломжийг бүрдүүлэх” хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн. Тус ажлын дагуу Хаягийн мэдээллийн сангийн хэрэглэгчдийн гаргах бичмэл болон хүснэгтэн тайлангийн загварыг гүйцэтгэгч байгууллагад хүргүүлснээр хаягийн мэдээллийн системээс 3 төрлийн тайлан гарах боломж бүрдүүлсэн хөгжүүлэлтийн ажил хийгдсэн. Үүнд:<br>- бичмэл тайлан<br>- хүснэгтэн болон тоон мэдээлэл<br>- хаягийн өгөгдөл, мэдээллийг харьцуулсан мэдээлэл<br>Хаягийн мэдээллийн систем нь админ болон нээлттэй веб гэсэн 2 төрлөөр шинээр хөгжүүлэгдсэн бөгөөд 4 төрлийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж байгууллага авах боломжтой болсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.5.10 | Хаягийн мэдээллийн системээс нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд шинээр хаяг олгох ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Хаягийн мэдээллийн системийг 21 аймгийн хэмжээнд нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Нийслэлийн ГЗБА-аас боловсруулан ирүүлсэн өгөгдөл мэдээллийг Хаягийн мэдээллийн системд хөрвүүлж, 9 дүүргийн хэмжээнд шинэчилсэн хаяг олгогдсон байна. | Нийслэлийн хэмжээнд хаягийг үнэн зөв, алдаагүй олгох зорилгоор олон улсын туршлагыг судлан 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр БНСУ-ын Төрийн захиргаа, аюулгүй байдлын яамны хаягийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон холбогдох байгууллагын 7 албан хаагчтай Монгол улсын хаягжуулалтын өнөөгийн байдал, Солонгос улсын хаягжуулалтын өнөөгийн байдал сэдвээр танилцуулга хийгдэж туршлага солилцсон.<br>Мөн 06 дугаар сарын 06-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос улсын зөвлөх, мэргэжилтнүүдтэй хамтран олон улсын техникийн шаардлагыг хангасан хаягийн мэдээллийн нэгдсэн системийг шинэчлэн байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийн төслийг боловсруулах хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулж, Бүгд Найрамдах Солонгос Улсын Хаягийн системийн давуу тал, манай улсад хэрэглэгдэж болохуйц шийдлийг судлан, нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 63572 гудамж, 529907 орц, гарц, 64201 замыг хөрвүүлэн оруулсан. Мөн нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нэгж талбар, барилгад хаяг олгох туршилтын ажлыг гүйцэтгэж, туршилтаас гарсан алдаа дутагдлыг Хаягийн мэдээллийн системийн хөгжүүлэлтэд тусган засварлуулсан бөгөөд иргэд, олон нийтэд нээлттэй, админ хэрэглэгчийн гэсэн 2 төрлөөр хөгжүүлэлт хийгдэж, хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болсон.<br>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь БНСУ-ын Дотоод хэрэг, аюулгүй яам, Газар геоматик (LX) корпорацтай хамтран “Монгол Улсын хаягийн мэдээллийн систем хөгжүүлэлтийг дэмжих төсөл”-ийг КОЙКА олон улсын байгууллагын дэмжлэгтэй 2025 оны 05 дугаар сараас хэрэгжүүлж эхлэхээр болсон бөгөөд төслийн дагуу нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар дүүргээс эхлэн хаягийн системийг хэрэглээнд нэвтрүүлэхээр болсон. | 90 |
| 2.1.5.11 | Хаягийн мэдээллийн системд бүртгэлтэй Улсын хэмжээний | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Хаягийн мэдээллийн системийг 21 | Улсын хэмжээний хаягийн мэдээлэл нарийвчлан шалгагдаж | Тус ажлын хүрээнд “Хаягийн нэгдсэн системийн хөгжүүлэлт (хаяг олгох үйл ажиллагааг автоматжуулах, цахимжуулах ажил)”-ын АД/2024- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хаягийн өгөгдөл мэдээллийг үндэсний ДАТА төвийн ХУР системд байрлуулж, бусад төрийн болон хувийн хэвшлийн байгууллага ашиглах боломжийг бүрдүүлэх | | | аймгийн хэмжээнд нэвтрүүлсэн. | алдаагүй, үнэн зөв мэдээлэл Үндэсний Дата төвийн ХУР системд байршиж төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд ашиглах боломжтой болсон байна. | 04 дугаартай ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Гэрээт ажлын төлөвлөгөөнд туссаны дагуу системийн хөгжүүлэлтийг хийлгэж, нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд хаяг олгох туршилтын ажлыг гүйцэтгэсэн. Хаягийн мэдээллийн системд бүртгэлтэй хаягийн өгөгдөл мэдээллийг үндэсний ДАТА төвийн ХУР системд байрлуулж, бусад төрийн болон хувийн хэвшлийн байгууллага ашиглах боломжийг бүрдүүлэхээр ДАН-ын нэвтрэх эрх авахаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд 1/2502 тоот албан бичгийг хүргүүлж, эрхийг нээлгэсэн.<br>Хаягийн мэдээллийн системд бүртгэлтэй хаягийн өгөгдөл мэдээллийг үндэсний ДАТА төвийн ХУР системд байрлуулж системийн нээлттэй вэбээр дамжуулан иргэд, олон нийт нэгж талбар, барилгын хаягийн тодорхойлолт, лавлагааг авах боломжтой болсон. | |
| 2.1.5.12 | Хаягийн өгөгдөл мэдээллийг засварлах, шинэчлэн зураглах ажлын даалгавар боловсруулан 21 аймагт хүргүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах | Үйл ажиллагаа | Арга зүй | Хаягийн мэдээллийн систем хэрэглээнд нэвтэрсэн. | Батлагдсан стандартын дагуу Хаягийн мэдээллийн систем дэх алдаатай өгөгдөл мэдээллийг засварлах арга зүйг боловсруулж, 21 аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн байна. | Хаягийн өгөгдөл мэдээллийг засварлах, шинэчлэн зураглах ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Үүнд:<br>- Нэгж талбар, барилга байгууламжийн орц гарц, гудамжны эхлэл, төгсгөл, зам, гудамж зураглах АД/2024/30 дугаартай загвар ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан.<br>- АД/2024/30 ажлын даалгаврын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын Хаягийн мэдээллийн систем дэх өгөгдөл, мэдээллийг засварлуулахаар Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 1/533 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>- 21 аймгийн ГХБХБГ-т 2/1655 дугаар албан бичгээр хаягийн мэдээллийн нэгдсэн системд хаяг олгох үйл ажиллагааг автоматжуулах, цахимжуулах ажил хийгдэж байгаатай холбоотой хаяг олгох, хаягийн өгөгдөл засварлах талаар чиглэл хүргүүлсэн. | 100 |



97

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - 21 аймгийн ГХБХБГ-т "Хаягийн мэдээллийн системд оруулах өгөгдөл, мэдээг зураглах аргачлал"-ыг 2/3308 дугаар албан бичгийн хавсралтаар тус тус хүргүүлсэн байна. | |
| **2.1.7** | **Газрын нэгдмэл сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Газрын нэгдмэл сангийн үйл ажиллагаа** | **Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санг нэвтрүүлсэн.** | **Газрын нэгдмэл сангийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.** | | |
| 2.1.7.1 | Газрын нэгдмэл санд орж буй шилжилт, хөдөлгөөнд тухай бүр хяналт тавих, тайлагнах, Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал шилжүүлэх саналыг www.egazar.gov.mn цахим хаягаар дамжуулан хүлээн авах боломжийг бүрдүүлэх | Урсгал зардал | Систем хөгжүүлсэн байдал | Газрын нэгдмэл сангийн цахим систем хэрэглээнд нэвтэрсэн. | **Эхний хагас жилд**:<br>Ажлын даалгаварт санал өгөх, гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлыг бүрэн хүлээн авсан байна. | Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага атар газрыг тариаланд шилжүүлэх саналыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэхээр заасан байдаг.<br>Дээрх хуулийн заалтыг үндэслэн Газрын нэгдмэл сангийн цахим системд холбогдох албан хаагчид эрх олгон, тухайн албан хаагч www.egazar.gov.mn цахим системээр дамжуулан саналыг холбогдох баримт бичиг болон тоон мэдээллийн хамт хүргүүлж, шийдвэрлүүлэх, шийдвэрлэлтийн явцтай танилцах боломжтой болсон. | 100 |
| 2.1.7.2 | Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилгуулах, Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажсан нэгж талбарын тоо | Газрын кадастрын мэдээллийн систем | **Эхний хагас жилд:**<br>Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилган Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажуулсан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилган Газрын | Улсын хэмжээнд жилийн эцсийн байдлаар Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй, зөрчилтэй нийт 6040 нэгж талбарыг Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн цахим системд нөхөн бүртгэж баталгаажуулсан байна.<br>Үүнээс: Архангай 215, Баян-Өлгий 284, Баянхонгор 165, Булган 145, Говь-Алтай 120, Говьсүмбэр 3, Дархан-Уул 37, Дорноговь 75, Дорнод 130, Дундговь 58, Завхан 150, Орхон 31, Өвөрхангай 128, Өмнөговь 96, Сүхбаатар 24, Сэлэнгэ 468, Төв 1155, Увс 61, Улаанбаатар 1688, Ховд 402, Хөвсгөл 484, Хэнтий 121 нэгж талбарыг тус тус нөхөн бүртгэгдсэн байна.<br>Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн цахим системд нөхөн бүртгэгдсэн нэгж талбарын тоон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | кадастрын мэдээллийн системд баталгаажуулсан байна. | үзүүлэлтээс хамгийн өндөр үзүүлэлттэй зориулалтыг дурдвал гэр, орон сууцны хашааны газар 2266, өвөлжөө, хаваржаа 1274, гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар 764, төмс, хүнсний ногооны тариалангийн газар 422, худалдаа, нийтийн үйлчилгээний газар 247, аялал жуулчлалын бааз 116 нэгж талбар тус тус бүртгэгдсэн байна. | |
| 2.1.7.3 | Газрын нэгдмэл сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн үйл ажиллагаа | Журам, дүрэм, стандартыг батлуулсан. | **Эхний хагас жилд:**<br>Батлагдсан журам, дүрэм, стандартын хүрээнд мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласан байна.<br>**Жилийн эцэст:**<br>Батлагдсан журам, дүрэм, стандартын хүрээнд мэргэжил, арга зүйгээр хангаж ажилласан байна. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Засгийн газарт өгсөн чиглэлийн хүрээнд Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй мэдээлэлд хяналт, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хяналт, шалгалтаар Газрын кадастрын мэдээллийн санд нийт 1'258'195 нэгж талбар бүртгэлтэй байгаагаас газар өмчлөх эрхтэй 642'557 нэгж талбар, газар эзэмших эрхтэй 608'412 нэгж талбар, газар ашиглах эрхтэй 7'226 нэгж талбар тус тус бүртгэлтэй байна.<br>Мөн гадаадын иргэнд 140 нэгж талбар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид 766 нэгж талбар, гадаадын хуулийн этгээдэд 1289 нэгж талбар, Монгол улсын иргэнд 1'201'446 нэгж талбар, Монгол улсын төрийн байгууллагад 20'225 нэгж талбар, Монгол улсын хуулийн этгээдэд 54'609 нэгж талбарыг тус тус өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулсан бүртгэлтэй байна.<br>21 аймгийн ГХБХБГ-ын кадастрын асуудал хариуцсан албан хаагчийг чадавхжуулах сургалтын хүрээнд Газрын нэгдмэл сангийн цахим системийн өгөгдөл, мэдээллийг засварлах, өөрчлөлт оруулах бүртгэх, газрын нэгдмэл сангийн тайлан гаргах чиглэлээр дадлага ажлыг хийж гүйцэтгүүлсэн.<br>Мөн Газрын кадастрын мэдээллийн санд буруу болон алдаатай бүртгэсэн мэдээллийн жагсаалтыг аймаг, сум тус бүрээр боловсруулж бэлтгэсэн бөгөөд алдаатай мэдээллийг хэрхэн засварлах, сайжруулах талаар чиглэл, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. | 100 |
| **2.1.15** | **Тусгай зөвшөөрөл болон мэргэжлийн** | **Үйл ажиллагаа** | **Системийн хөгжүүлэлт** | **2021 онд Салбарын тусгай** | **Салбарын тусгай зөвшөөрөл,** | | |



99

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **байгууллагын эрх олгох, сунгах, хүчингүй болгох, хяналт тавих ажлыг зохион байгуулах** | | | **зөвшөөрөл. мэргэжлийн байгууллын эрх олгох, тэдгээрт хяналт тавих системийг хэрэглээнд нэвтрүүлсэн.** | **мэргэжлийн байгууллын эрх олгох, тэдгээрт хяналт тавих системд хөгжүүлэлт хийж, хяналтыг сайжруулсан байна.** | | |
| 2.1.15.5 | Салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, тайланг хүлээн авч хянан гэрээг дүгнэж, акт үйлдэх | Үйл ажиллагаа | Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тоо | 2023 онд хүсэлт ирүүлсэн 48 аж ахуйн нэгжийн ажилд хяналт хийж, дүгнэлтээр АМХ-т хүлээлгэн өгсөн.<br>2023 оны 451 тайланг хуулийн этгээдүүдээс цахим системээр хүлээн авсан. | **Эхний хагас жил:**<br>Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн 2023 оны үйл ажиллагаа эрхэлсэн дэлгэрэнгүй тайланг хянаж, мэдээллийн санд тэмдэглэл хөтөлнө.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн 2024 оны тайланг хүлээн авч, хяналт тавина. | Газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий “Вектор мэп” ХХК, “Газар дэлхий” ХХК, “Ланрес” ХХК, “Инженер геодези” ХХК-ууд 2023 онд хийгдсэн Газрын кадастрын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайланг цахим системээр ирүүлсэн байгааг хянаж, шалган акт үйлдэн баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэж байна. | 100 |

## ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ-лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3.1<br>Улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ.** | | | | | | | |
| **3.1.7** | **Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл, газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах** | **Үйл ажиллагаа** | **Газрын нэгдмэл сангийн 2022 оны улсын нэгдсэн тайлан** | **Газрын нэгдмэл сангийн 2021 оны улсын нэгдсэн тайлан Засгийн газарт танилцуулагдсан.** | **Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэлийн үйл ажиллагааг эрхэлж газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн бүртгэгдсэн байна.** | | |



100

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.7.1 | Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг аймаг, нийслэлээс хүлээн авч нэгтгэх, улсын нэгдсэн тайланг гарган Засгийн газарт танилцуулах, Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлангийн товхимлыг хэвлүүлэх, тайланг хэрэглэгчдэд хүргэх | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлан, товхимол | Газрын нэгдмэл сангийн 2022 оны улсын нэгдсэн тайлан хэвлэгдсэн. | **Эхний хагас жилд:** Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлан Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд танилцуулагдсан байна. Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлангийн товхимол хэвлэгдэн хэрэглэгчдийн хүртээл болсон байна. | Газрын нэгдмэл сангийн тайланг аймаг, нийслэлээс хүлээн авах, нэгтгэн гаргах ажлын хэсгийг Газрын даргын 2024 оны А/01 тоот тушаалаар байгуулан тайлан хүлээн авах, нэгтгэх хуваарийг батлуулсан.<br>Аймаг, нийслэлийн газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг ажлын хэсгийн гишүүд шалган хүлээн авч нэгтгэн гаргалаа. Мөн улсын хэмжээний 2023 тайланг нэгтгэн 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд хурлаас гаргасан шийдвэрийн дагуу Монгол улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 14 дүгээр хуралдаанд танилцуулсан.<br>21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-нд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэлийг 2024 оны 1/1076 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайланг хэвлэх гүйцэтгэгчтэй 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 2024/126 дугаар гэрээ байгуулан, гэрээний дагуу 500 ширхэг тайланг хүлээн авсан.<br>Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайланг ЭХЯ, ЦХХХЯ, ХХААХҮЯ, АҮЭБЯ, ХЗҮХ, УЦУОСМХүрээлэн, УБЕГ, Хот байгуулалт, хотын стандартын газар, Үндэсний статистикийн хороо зэрэг нийт 26 аж ахуйн нэгж, байгууллагад тус тус албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 3.1.7.2 | Байгаль орчны төлөв байдлын БОХ-1.1, БОХ-1.2 тайланг гаргаж, БОАЖЯ-нд хүргүүлэх, газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайланг Байгаль орчны мэдээллийн төв, Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх | Үйл ажиллагаа | 2023 оны БОХ-1.1, БОХ-1.2 тайлан | Газрын нэгдмэл сангийн 2022 оны улсын нэгдсэн тайлан Засгийн газарт танилцуулагдсан. | **Эхний хагас жилд:** 2023 оны БОХ-1.1, БОХ 1.2 тайланг гаргаж, БОАЖЯ-нд хүргүүлсэн байна.<br>Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайланг нэгтгэн гаргасан бөгөөд тухайн тайланд тусгагдсан мэдээллийн дагуу Байгаль орчны төлөв байдлын БОХ-1.1, БОХ-1.2 тайланг https://eic.mn/box/index.php цахим системд оруулж, баталгаажуулсан.<br>Мөн газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайланг улсын статистикийн эмхэтгэлд оруулахаар uyangaa@nso.mn хаягаар хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **3.1.12** | **Газрын зөрчил, маргаантай холбоотой асуудлыг шийдвэрлэх, холбогдох арга хэмжээг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийн тоо** | **2024 оны эхний хагас жилийн байдлаар иргэний болон захиргааны шүүх, Авлигатай тэмцэх газар, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн 179 албан бичиг, иргэний 39 өргөдлийг шийдвэрлэсэн.** | **Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах, дүгнэлт гаргах, нотлох баримтыг хүргүүлсэн байна.** | | |
| 3.1.12.1 | Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах, дүгнэлт гаргаж хүргүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийн тоо, тушаалын биелэлт | 2024 оны эхний хагас жилийн байдлаар 18 ажлын хэсэг байгуулж, 18 шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн. | **Эхний хагас жилд:** Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажлын хэсэг байгуулах тухай газрын даргын тушаал гарсан байна. Газрын даргын тушаалаар болон бусад байгууллагатай зөвшилцөн байгуулагдсан ажлын хэсэгт ажиллана. Шинжээчийн дүгнэлтийг хүргүүлсэн байна. | Нийслэл, дүүргийн иргэний болон захиргааны хэргийн анхан шатны шүүх, Авлигатай тэмцэх газар, бусад эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангаж 28 ажлын хэсэг байгуулж, холбогдох шинжээчийн дүгнэлтийг гарган ажилласан. Үүнээс 19 хэрэгт геодезийн хэмжилт зураглалын ажлыг гүйцэтгэсэн. Эдгээр шинжээчийн дүгнэлтийн ажлын хэмжилт зураглалыг хийж гүйцэтгэхдээ 2 долгионы TRIMBLE R8 GPS багаж болон Leica фирмийн электрон тахеометр багажуудыг ашиглан улсын геодезийн солбицлын ITRF-2008 тогтолцоо, UTM тусгагд суурилан гүйцэтгэсэн ба хэмжилтийн үр дүн дата боловсруулалтын ажлыг AutoCAD2020 программ хангамж болон ЛМ, QGIS, ArcGIS программ хангамжуудыг ашиглан гүйцэтгэсэн. Мөн 4 шинжээчийн дүгнэлтэд шаардлагатай зардлын тооцоог хүргүүлж, дүгнэлтийг боловсруулан ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.12.2 | Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллага, иргэний хүсэлтийн дагуу нотлох баримтыг гаргаж холбогдох байгууллага, иргэнд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Албан тоот, өргөдөл хүсэлт | 2024 оны эхний хагас жилийн байдлаар иргэний болон захиргааны шүүх, Авлигатай тэмцэх газар, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн 179 албан бичиг, иргэний 39 өргөдлийг шийдвэрлэсэн. | **Эхний хагас жилд:** Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллага, иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлын дагуу нотлох баримтыг хүргүүлсэн байна. | Тус ажлын хүрээнд нотлох баримт, газрын түүхчилсэн лавлагаа, нэгж талбарын хувийн хэрэг хүссэн нийт 395 албан бичиг, 97 өргөдөл ирснийг шийдвэрлэсэн байна. Үүнд аймаг, нийслэл, дүүргийн захиргааны болон иргэний хэргийн шүүхээс 250, Авлигатай тэмцэх газраас 53, Цагдаагийн ерөнхий газар болон Тагнуулын ерөнхий газраас нийт 92 өргөдөл ирүүлсэн байна. | 100 |

## ДӨРӨВ. НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1 | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | Үйл ажиллагаа | Үүрэг даалгаврын тоо | Жил бүр | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна. | - Газрын тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 07-нд орсон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Газрын удирдлагын нэгдсэн цахим систем (egazar,gov.mn)-ээр дамжуулан шинээр газар эзэмших хүсэлт илгээх хөгжүүлэлтийн ажлыг Эрхэт инноваци ХХК-тай хамтран гүйцэтгэсэн.<br>- Аймаг, нийслэлийн Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг хүлээн авах ажлын хүрээнд 21 аймгийн ГХБХБГ-ын албан хаагчид болон сумдын даамлуудад чиглэл өгч ажилласан бөгөөд нэгдмэл сангийн тайланг хүлээн авч ДДЗХ-аар хэлэлцүүлэн ЗГ-т танилцуулах арга хэмжээг зохион байгуулж ажилласан.<br>- Монгол Улсын Ерөнхий сайд агентлагийн үйл ажиллагаатай танилцах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө болон системүүдийн танилцуулгыг бэлтгэж газрын даргад танилцуулсан.<br>- "Нийслэл, 21 аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сангийн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх" нэмэлт хөгжүүлэлтийн сургалтыг 2024 оны 02 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулж ажилласан.<br>- ЗГ-ийн 2020 оны 110 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, ГНС-ийн удирдлагын нэгдсэн цахим системийг сайжруулахтай холбоотой арга хэмжээг зохион байгуулж ЗГХЭГ-ийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийн хэрэгжилтийг хангаж УБЕГ, Ашигт малтмал, газрын тосны газар, Зам тээврийн хөгжлийн яам, Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар, Захирагчийн ажлын алба, Ус сувгийн удирдах газруудтай хамтран ажиллаж ажлын хэсгийг тус бүр байгуулан ажиллаж байна.<br>- 2023 оны газрын нэгдмэл сангийн тайланг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд шаардлагатай хураангуй танилцуулга, шийдвэрийн төслийг бэлтгэж газрын даргын 2024 оны 1/86 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>- БНСУ-ын LX корпорацын төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж газарзүйн мэдээллийн систем, хаягийн мэдээллийн системийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал солилцох үйл ажиллагааг 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэл зохион байгуулж ажилласан.<br>- Стрийм төсөлтэй хамтран Хэнтий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нийт албан хаагчдад Газрын кадастрын мэдээллийн систем болон газрын нэгдмэл сангийн тайлан гаргахтай холбоотой танхимын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдөр зохион байгуулсан.<br>- УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан газрын сонсгол хийхтэй холбоотой байгуулагдсан ажлын хэсэгт улсын хэмжээний 2003-2023 оны хооронд Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэгдсэн иргэн хуулийн этгээдэд олгосон газрын нарийвчилсан судалгааг гаргаж МУИХ-ын ЭЗ-ийн байнгын хороонд хүргүүлсэн.<br>- Монгол Улсын Ерөнхийлөгчийн өгсөн үүрэг чиглэлийн хүрээнд 21 аймгийн 41 сумыг болон нийслэлийн 9 дүүргийг сонгон авч газар олголттой холбоотой хяналт шалгалтын ажлын тайланг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар хуралдаанд танилцуулсан бөгөөд хуралдааны тэмдэглэлээс өгсөн үүрэг даалгаварын хүрээнд аймаг, нийслэлийн Засаг даргад хэрэгжилтийг хангаж ажиллах талаар албан бичгийг хүргүүлж ажилласан. Мөн хяналт, шалгалтын ажлын тайланг Засгийн газрын хэрэг эрхлэн газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар,т 2024 оны 1/2161, 1/2162, 1/2163, 1/2897 дугаар албан бичиг тус тус хүргүүлж ажилласан.<br>- Орон нутгийн албан хаагчдын мэдлэг чавдарыг дээшлүүлэх, чадавхжуулах ажлын хүрээнд 21 аймгийн ГХБХБГ-ын кадастрын асуудал хариуцсан албан хаагчдад 2024 оны 05 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд танхимын сургалт зохион байгуулсан.<br>- Шинээр газар эзэмших хүсэлтийг И-Монголиа системд линк үүсгэж үйлчилгээг холбож 2024 оны 05 дугаар | |



w5

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын 27-ны өдрөөс хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>- Салбар дахь нийгмийн бүлгүүд болох ахмадын бүлэг, мэргэжлийн байгууллагын удирдлагууд, багш, эрдэмтэд, судлаачдад агентлагийн үйл ажиллагаа, цахим систем, хууль эрх зүйн орчинд хийгдэж байгаа шинэчлэлийг сурталчлах зорилгоор Монголын кадастрын холбоотой хамтарсан уулзалтыг 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан.<br>- Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайлангийн хэвлэлийн эхийг хянаж, товхимол хэвлүүлсэн.<br>- Байгууллагын цахим хуудасны шинэчилсэн хувилбарт ГКМС болон хаяг, Газрын нэгдмэл сангийн цахим систем, Хот байгуулалтын системүүдийн танилцуулгыг байршуулсан бөгөөд egazar.gov.nm системээс авах 23 төрлийн үйлчилгээг хэрхэн авах талаар зааварчилгааг бэлтгэж оруулсан.<br>- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн төлөвлөгөөний төсөлд гурав болон дөрвөн /3D, 4D/ хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх, хаягийн мэдээллийн системийг шинэчлэн байгуулах, газрын нэгдмэл сангийн өгөгдөл бүрдүүлэх зэрэг ажлуудыг нарийвчлан тусгаж ОЗӨДБГазарт 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.<br>- Засаг даргын захирамж шийдвэр гаргуулах, гэрчилгээ олгох ажлыг эрчимжүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байгаа талаар мэдэгдэж, 21 аймгийн ГХБХБГазарт 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдөр | |



100

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1/1814 дугаартай албан бичиг хүргүүлсэн.<br>- ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/268 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороонд ажиллаж, "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг байгууллагуудын мэдээллийн сантай холбож, дундын мэдээллийн санг байгуулах" үйлчилгээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан.<br>- "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, салбар хоорондын холбогдох үйл ажиллагааг уялдуулах ажлыг зохион байгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах төслийг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 60 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулсан.<br>- БНСУ-ын Дотоод хэрэг, аюулгүй байдлын яамны сайд Ли Санг Мин-ны Монгол Улс дах айлчлалтай холбоотой Сөүлийн гудамжинд хаягийн тэмдэглэгээний дурсгалын самбар байршуулах ёслолын ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж хаягжуулалттай холбоотой танилцуулга, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах, хаягийн тэмдэг байршуулах ажиллагааны нээлтийн үг бэлтгэх, хаягийн тэмдэгтийн эх бэлтгэлийн ажлыг хийж гүйцэтгэн ОЗӨДБГ-ын холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.<br>- Газрын даргын 2024 оны А/87 тушаалаар байгуулагдсан "Евроазийн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн 10 дугаар хурлын бэлтгэл ажлыг хангах, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулах" ажлын хүрээнд хэлтсийн танилцуулгыг англи хэл дээр бэлтгэж, ОЗӨДБГ-т хугацаанд нь хүргүүлсэн.<br>- Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 60 дугаар захирамжаар байгуулсан "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, салбар хоорондын холбогдох үйл ажиллагааг уялдуулах ажлыг зохион байгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн анхдугаар хуралдааныг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хуралдуулсан.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 136, 71, 131 дүгээр "Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах, газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай" тогтоолын дагуу иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр газар эзэмшүүлэх үйл ажиллагааг egazar.gov.mn цахим системээр дамжуулан зохион байгуулж, нийт 46,741 хүсэлтийг хүлээн авч, 4765 иргэн хүсэлтээ баталгаажуулснаас 2791 иргэнд цахимаар гэр бүлийн хэрэгцээнд үнэгүй газар эзэмшүүлсэн. | |
| 4.1.2 | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Тушаалд заасан хугацаа | Жил бүр | Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна. | - Газрын даргын 2024 оны А/34 тушаалаар байгуулагдсан "Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журмын төсөл боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан.<br>- Газрын даргын 2024 оны А/02 тушаалаар байгуулагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан. | 100 |



108

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Газрын даргын 2024 оны А/18 тушаалаар байгуулагдсан "Нийтийн сервитут тогтооход нөхөх олговрын хэмжээг тооцох, нөхөх олговрыг тогтоох, нөхөх олговрыг дүйцүүлэн тооцох журам боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан.<br>- "Газар зохион байгуулалтын ажлын үнэлгээ, цахим систем болон орон зайн өгөгдлийн мэдээллийн сангаас үзүүлэх үйлчилгээ, лавлагаа, мэдээлэл авах үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох" журмыг шинэчлэн батлуулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан.<br>- МУ-ын Ерөнхийлөгчийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 3Г-т өгсөн чиглэлийн дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/17 дугаар тушаалаар ажлын хэсэг 6 багийн 24 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгууллагдан хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтын ажлын тайланг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар хуралдаанд танилцуулсан бөгөөд хуралдааны тэмдэглэлээс өгсөн үүрэг даалгаварын хүрээнд аймаг, нийслэлийн Засаг даргад хэрэгжилтийг хангаж ажиллах талаар албан бичгийг хүргүүлж ажилласан. Мөн хяналт, шалгалтын ажлын тайланг Засгийн газрын хэрэг эрхлэн газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар,т 2024 оны 1/2161, 1/2162, 1/2163, 1/2897 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн.<br>- Газрын даргын 2024 оны А/235 тушаалаар байгуулагдсан "Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн цаасан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон цахим ном" хийх ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсэгт орж ажилласан.<br>- Ашигт малтмал, газрын тосны газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/99, А/260 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:<br>1.Засгийн газраар батлуулсан сонгон шалгаруулалтаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг шалгах, улсын хэмжээнд тухайн жилд өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох нийслэл, орон нутгийн саналыг хянаж, дүгнэлт, зөвлөмж гаргах.<br>2.Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн систем болон Уул уурхайн кадастрын бүртгэлийн системийн хоорондын уялдааг хангах, бодит цагийн мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх талаар судалгаа хийж, шийдлийг тодорхойлох.<br>- Газрын даргын 2024 оны А/87 тушаалаар байгуулагдсан "Евроазийн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн 10 дугаар хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах" үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж бэлтгэл хангасан ба хурлын үеэр гадаад, дотоодын төлөөлөгч, зочдод ГУНЦС egazar.gov.mn болон газрын харилцааны цахим машин киоск төхөөрөмжөөс үзүүлж буй үйлчилгээний талаар танилцуулж ажилласан.<br>- МУ-ын Ерөнхий сайдын 2016 оны 91 дүгээр захирамжаар байгуулагдсан "Монгол Улсад байгаа ОХУ-ны үл хөдлөх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эд хөрөнгийн маргаантай асуудлыг зохицуулах" үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, 2024.09.23, 09.27, 12.04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан хурлуудад оролцсон. Хурлаар хэлэлцсэн асуудлын хүрээнд санал болловсруулж, газрын даргын 2024.10.08-ны өдрийн 1/2680 дугаартай албан бичгээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн.<br>- Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 60 дугаар захирамжаар байгуулсан "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, салбар хоорондын холбогдох үйл ажиллагааг уялдуулах ажлыг зохион байгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг"-ийн анхдугаар хуралдааныг зохион байгуулж ажилласан. | |
| 4.1.3 | Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | Жил бүр | Холбогдогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна. | - Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар хуралдааны тэмдэглэлээс өгсөн үүрэг даалгаварын хүрээнд аймаг, нийслэлийн Засаг даргад хэрэгжилтийг хангаж ажиллах талаар албан бичгийг хүргүүлж ажилласан. Мөн хяналт, шалгалтын ажлын тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 2024 оны 1/2161, 1/2162, 1/2163, 1/2897 дугаар албан бичиг хүргүүсэн.<br>- ЗГ-ын 2023 оны 234 дүгээр тогтоолын нэгдүгээр заалтын дагуу Тусгай хэрэгцээний газар, нийтийн эдэлбэрийн газар, зам, шугам сүлжээний газар, ойн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон усны сан бүхий газар, тэдгээрийн хамгаалалтын бүс газарт хууль тогтоомж зөрчин газар эзэмшиж, ашиглаж байгаа, барилга байгууламжийн судалгааг гаргасан.<br>- ЗГ-ын 2024 оны 58 дугаар тогтоолын хоёрдугаар заалтын дагуу Төмөр замын шугамын чигтэй давхацсан газрыг чөлөөлөх, шинээр газар олгохгүй байх нөхцөлийг бүрдүүлж ГКМС-ийн нууцын давхаргад бүртгэж хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>- ЗГ-ын 2023 оны 13 дугаар тэмдэглэлийн 4.2 дах заалтын дагуу хууль, журам зөрчиж газар олгохгүй байх нөхцөлийг бүрдүүлж газрын нэгдмэл сангийн цахим системээр дамжуулан хяналт тавих, газар олголтыг нээлттэй, ил тод болгох арга хэмжээний хүрээнд egazar.gov.mn системд газар эзэмшигч, ашиглагчийн мэдээллийг нээлттэй харагдуулах хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.<br>- ЗГ-ын 2023 оны 13 дугаар тэмдэглэлийн 4.3 дах заалтын дагуу төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшлийн болон нийтийн эдэлбэр газрыг бусдад эзэмшүүлсэн, зориулалтыг өөрчилсөн, барилга байгууламж барьсан талаарх судалгааг 1996 оноос гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн.<br>- "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан КХ-ээс хариуцан хэрэгжүүлж буй 5 арга хэмжээний биелэлтийг нэгтгэж, ТЗУГ-т хугацаанд нь хүргүүлсэн.<br>- Засгийн газрын 100 хоногт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан КХ-ээс хариуцан хэрэгжүүлж буй 3 арга хэмжээний биелэлтийг нэгтгэж, ТЗУГ-т хугацаанд нь хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн сэтгүүл, ном товхимолд хэвлэгдэх КХ-ээс хариуцан хэрэгжүүлж буй ажлуудын мэдээллийг нэгтгэж, холбогдох ажлын хэсгүүдэд хугацаанд нь хүргүүлсэн.<br>- 2021-2024 онд баримталж, хэрэгжүүлсэн хөгжлийн бодлогын баримт бичгийн үр дүн, үр нөлөөний мэдээллийг боловсруулж, ГСШБТГ-т хүргүүлсэн.<br>- Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн хэрэгжилтийн талаар КХ-ээс хамааралтай 7 заалтын хэрэгжилтийг нэгтгэж, ТЗУГ-т хүргүүлсэн. | |
| 4.1.4 | Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | Үйл ажиллагаа | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | Жил бүр | Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Хэлтсийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 870 албан бичиг хуваарилагдан ирснээс хариутай 592, хариугүй 278 албан бичиг байна. Хариутай 592 бичгийн 568-г нь шийдвэрлэсэн, 24 албан бичиг хяналтын шатанд байна.<br>Мөн иргэдээс нийт 267 өргөдөл, хүсэлт ирснээс 257-ыг нь шийдвэрлэн хариуг өгсөн бөгөөд 10 өргөдөл хяналтын шатандаа байна. | 100 |
| 4.1.5 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Үйл ажиллагаа | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | Жил бүр | Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | -Хэлтсийн хэмжээнд иргэн хуулийн этгээдээс ирүүлж шийдвэрлэсэн нийт 859 албан бичиг, өргөдөл гомдлын цаасан материалыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архив мэдээллийн төвд хүлээлгэн өгсөн.<br>-Хаягийн нэгдсэн системийн хөгжүүлэлт (хаяг олгох үйл ажиллагааг автоматжуулах, цахимжуулах ажил) 2024/72 дугаар гэрээт ажлын холбогдох баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэн, хадгаламжийн нэгжид хүлээлгэн өгсөн.<br>-Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг байгууллагуудын | 100 |



115

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийн сантай холбож, дундын мэдээллийн санг байгуулах, ГЗБГЗЗГ/20240102030 дугаартай үйлчилгээний тендер шалгаруулалтын хувийн хэргийг бүрдүүлж, хадгаламжийн нэгжид хүлээлгэн өгсөн. | |

## ТАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|
| 5.1.1 | Программ хангамжийн Python хэл дээр модуль хийсэн байна. | Газар зүйн мэдээллийн систем дээр нэмэлт хөгжүүлэлтийн ажил хийх ур чадвар эзэмшсэн байна. | Программ хангамжийн Python хэл дээр модуль хийсэн байна. | Газар зүйн мэдээллийн систем дээр нэмэлт хөгжүүлэлтийн ажил хийх ур чадвар эзэмшсэн болно. | 100 |
| 5.1.2 | Магистрт элсэж, суралцсан байна. | Магистрын зэргээ хамгаалсан байна. | Магистрт элсэж, суралцсан байна. | Магистрт элсэж, суралцсан болно. Үзэх шаардлагатай бүх хичээлийг үзэж төгссөн юм. Одоо диплом бичих ажлыг хийгдэж байгаа бөгөөд хугацаандаа хамгаалах болно.. | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГА П.БАЯНТҮМЭН